

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Тендерийн код: МРЦМ/20240202008
2. Багц: Техник тоног төхөөрөмж
3. Багцын нэр : Шигшүүр
4. Захиалагч: “МРЦМ” ТӨҮГ, “Бор-Өндөр” УБҮ, Баяжуулах фабрик

### Мэдээлэл:

ҮК1845 шигшүүрийг Хэнтий аймгийн “Бор-Өндөр” суман дахь “МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ -ийн харъяа “Бор-Өндөр”-ийн УБҮ -ийн “Баргилтын төмрийн хүдрийн ил уурхай”-н төмрийн хүдэр хуурай аргаар ангилан ялгах баяжуулах технологийн шугамд ашиглана.

### Шигшүүрийн тодорхойлолт

1. Шигшүүрийн марк ҮК1845
2. Шигшүүрийн гадаргуу хайрцаг буюу хавтасны хэсэгт хөндөл, рам зэрэг нь хадаас хэлбэрийн бэхэлгээгээр, голын холхивчны үүр нь болтон бэхэлгээгээр угсрагдаж бэхлэгдсэн байна.
3. Шигшүүрийн гадаргуу хайрцаг буюу хавтасны хэсгийг дээд, доод 4 ширхэг хөндлөөр бэхэлсэн, материал ангилан ялгах тор угсрагдах тавцан нь 2 хавтсыг дагасан булан төмрөөр хийгдсэн байна.
4. Шигшүүрийн кардан гол нь шигшүүрийн тор тавигдах хэсгийн дээд талд байрласан байна.
5. Шигшүүрийн материал ангилан ялгах тор угсрагдах хэсэгт уртын дагуу тус бүр 4 ширхэг, ф100мм хөндлүүд байрлана.
6. Шигшүүрийн цахилгаан хөдөлгүүр нь шигшүүрийн зүүн талд байрлахаар хөтлөх голыг тус тус угсарсан байна.
7. Пүрш нь нэг тулгуурт хос, нийт 8 ширхэг пүрш байна.
8. Шигшүүрийн файзны зургийг хавсаргав.

### Шигшүүрийн техникийн үзүүлэлт

№	Шалгуурын нэр	Хэмжих нэгж	Тоон утга
1	Тэжээлийн хүчин чадал	Тн/цаг	100-350
2	Хэмжээ (урт, өргөн, өндөр)	ихгүй, мм	4510x1940x820
3	Шигшүүрийн давхаргын тоо	-	1
4	Пүршний тоо	ш	8
5	Пүршний суурь хоорондын зай	мм	3240
6	Хазайлтын өнцөг	градус	15
7	Чичиргээний давтамж	мин	970-1000
8	Чичирхийллийн далайц	мм	7-9
9	Цахилгаан хөдөлгүүрийн чадал, кВт		22 кВт 1000 эрг/мин

/2024 онд хийгдэх нийлүүлэлтийн хуваарь/

Тоног төхөөрөмжийн нэр	Нийт захиалах тоо и/б	2024 онд хийгдэх нийлүүлэлтийн хуваарь / улирлаар /
		II улирал
ҮК1845 шигшүүр	1	1

Шигшүүрийн файзны зураг



Шигшүүрт тавигдах шаардлага:

1. Шигшүүр нь үзүүлсэн эд ангийн дугаартай нийцэх эсвэл дүйцэхүйц, хэлбэр, хэмжээг техникийн үзүүлэлтэнд тусгаснаар шууд суурилуулан ашиглахад бэлэн, бүрэн угсрагдсан иж бүрдэл байна.
2. Шигшүүр нь иж бүрдэлдээ гадаргуу хайрцаг (хажуугийн хавтан, түүний холбогч дээд, доод ган хоолой, бэхэлгээний хөндлүүд) хөтлөх, хөтлөгдөх гол, түүнд угсрагдсан чичрүүлэгч араа, голын үүр, чагтан гол түүний хамгаалалт, дээд суурь, доод суурь, хос пүрш, холбогч муфт, цахилгаан хөдөлгүүр зэрэг иж бүрдэл тоног төхөөрөмж байна.
3. Шигшүүр 2022 оноос хойш үйлдвэрлэгдсэн байна.
4. Шигшүүрт үйлдвэрлэсэн он, эдийн дугаар болон жингийн үзүүлэлтийг шошго, файзаар үзүүлнэ.
5. Үйлдвэрлэлийн техникийн баримт бичиг, гэрчилгээ дагалдах ба хадгалах горимын дагуу сав баглаа боодолтой хуучралт үүсээгүй байна.